



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/14

Зуунмод

Тооллого явуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 70 дугаар зүйлийн 70.4, Сангийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 126 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах журам" /код 136/-ын 136.4.2-ын "а", "в" дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явагдаж байгаатай холбогдуулан Цагдаагийн газрын үндсэн хөрөнгийг тоолох тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.

2. Тооллогыг 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд нүд үзэн чанартай тоолж, дүнг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлэхийг тооллогын комиссын дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/, ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Н.Дашдаваа/ нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



А.БАТБАЯР

Tushaal

45000198

Цагдаагийн газрын даргын 2016 оны  
05 дугаар сарын 17-ны өдрийн А/14  
тоот тушаалын хавсралт

**ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Тооллогын комиссын дарга:

-Б.Анхбаатар-Төлөвлөлт, зохион  
байгуулалтын тасгийн дарга,  
цагдаагийн хошууч

Гишүүд:

-Б.Доржсүрэн-Аж ахуйн ажилтан,  
цагдаагийн ахлах ахлагч,

А.Энхгэрэл-Заамар сум дахь сум  
дундын Цагдаагийн хэлтсийн  
бичээч-нярав, цагдаагийн дэд  
ахлагч,

Б.Алтансүх-Эргүүлийн цагдаа,  
цагдаагийн дэд ахлагч,

-Б.Ариунтуяа-Саатуулах байрны  
эмч, цагдаагийн дэслэгч.

**ЦАГДААГИЙН ГАЗАР**